

ПОЧТОВАЯ МАРКА МОНГОЛИИ (БУДДИЙСКИЕ АСПЕКТЫ)

Аннотация. Исторические корни уникальной почтовой структуры монголов уходят глубоко в их этнокультурную историю и традиционный кочевой образ жизни. Уже в 1235 году Угэдей Хан издал Указ об учреждении постоянных почтовых станций и дорог. В результате Народной Революции 1921 года начинается новая эра истории монгольской Почтовой службы, а первая почтовая марка была выпущена в 1924 году. Марки в традиционном монгольском обществе выпускались на различные темы и известные события. Одной из актуальных тем почтовых изданий были марки, посвященные религиозной тематике, в основном – буддизму. За 90 лет исторического развития и эволюции почтовых марок Монголии в большей степени преобладала буддистская этнокультурная тематика, в особенности, иллюстрации религиозных мистерий и масок Цам, художественные работы Ундэр Гегена Занабазара, внешний вид крупных монастырских комплексов и храмов (1970-1980 гг.). Однако за последнее десятилетие буддийская тематика намного расширилась, были выпущены не только марки, но и конверты, и прочие атрибуты, отражающие феноменальные особенности монгольской культуры, включая изображения главных буддийских монастырей и храмов, расположенных в Улан-Баторе, таких как: Музей Дворец Богдо Хана, Монастырь Дашичойлинг и Монастырь Чойджин Ламы, а также марки и конверты, проведенных в их честь выставок, изображения мировых буддийских религиозных лидеров, знаменательные даты их биографии и жизнедеятельности.

Статья содержит также исторические заметки и интерпретацию истории почтовых марок Монголии, представлена картина мира монголов в контексте их адаптации почтовой службы, и некоторые особенности филателических проблем в системе традиционной жизни монгольских народов. В 2004 году Монголия выпустила на международную арену, в контексте мировых почтовых отношений, самую большую марку «Мандала Мира», как визитную карточку современной Монголии.

³³ Монгол хэл-хэлшинжлэлийн тэнхим Хүмүүнлэгийн Ухааны Салбар Шинжлэх Ухааны Сургууль Монгол Улсын Их Сургууль Улаанбаатар, Монгол Улс, e-mail: bsarantuya@yahoo.com.

Ключевые слова: уртонная служба, почтовая марка, филателия, истории марки, старинные марки, элдэв-очир, самая большая марка, монастыри и храмы, буддийские аспекты.

BIZYAAGIYN SARANTUYAA

POSTAGE STAMP OF MONGOLIA (BUDDHIAN ASPECTS)

Abstract: The roots of the history of mongolian post creating go to the establishing of postriders service. In 1235, Ugudei Khan issued the Ruling on establishment of permanent stations of roads.

In the result of the People's Revolution of 1921 the new era of history of Mongolian Postal service began, and the first postal mark was issued in 1924. One of the themes of postal marks has been devoted to the religious theme.

In 90 years history of mongolian postage stamps, there prevail marks on Buddhist religious themes, in particular illustrations of religious dance masks, art works of Undur Gegeen Zanabazar, and monasteries and temples, in 1970-1980s. However, in recent 10 years, there have been released marks and envelopes attracting mongolian culture, including main monasteries and temples located in Ulaanbaatar such as Bogd Khan Palace-Museum, Dashichoiling Monastery, and Chojjin Lama Monastery and their exhibits as well as images of the world religious leaders, their life and work.

The article contains explanations and stories related to the above mentioned marks and brief outline of opinions with respect to the mark terms, some issues on philately. In 2004, Mongolia introduced to the world postal relations the biggest mark "Peace Mandala" as a name card of Mongolia.

Keywords: postage stamp, philately, history of the brand, old stamps, eldev-ochir, the largest stamp, monasteries and temples, Buddhist aspects.

Филатели - (Philately) шуудангийн марк, дугтуй, ил захидал судлах, цуглуулах шинжлэх ухаан. **Аливаа улсын марк бол** тухайн улсын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг, урлагийн бүтээл, соёлын үнэт зүйл, түүхэн хөгжлийн баримт, түүхэн үйл явдал, байгаль ан амьтан, ёс заншлыг сурталчлах сурталчилгааны хэрэгслээс гадна цаг хугацаа, судалгаа шинжилгээний нарийн чимхлүүр ажил шаардаж олон хүний хүч хөдөлмөр шингэж бүтдэг шуудангийн үнэт цаас юм.

Шуудангийн марк анх Англи улсад 1840 онд тавдугаар сарын 1-нд "Хар пенни" хэмээн алдаршсан /хатан хаан Викториягийн дүрс

бүхий/ маркийг зураач Гарольд Хиллийн зурснаар хэвлэсэн. 1926 онд Олон улсын маркийн холбоо байгуулагдсан бөгөөд манай улс 1975 оны 4-р сард гишүүнээр элссэн.

Монголын өртөө шуудангийн түүхээс онцолбол монгол шуудангийн түүх эрт үеэс буюу X-XI зуунаас улбаатай бөгөөд Кидан, Хүннү зэрэг Монгол овог аймгуудын өртөөний зохион байгуулалт болох уургын улаачаас эхлэл нь тавигдсан гэж үздэг. Энэ өртөө улаачийн алба эртний монголчуудын овог аймгуудын ахлагч, эрх мэдэл бүхий хүмүүсийн хооронд чухал мэдээ солилцохоос гадна дайн байлдаан, ахуйн амьдрал, бэлчээр усны эзэмшил тэдгээрийг сэлгэх нүүдэллэх зэргээс шалтгаалан хол ойроос хамааран тэдгээрийн мэдээллүүд чухалчилдаг байсан байна.

1206 онд Чингис хаан Хамаг Монголын нэгдсэн төр улсыг байгуулан улмаар дэлхийд хамгийн том эзэнт гүрнийг байгуулан захирчээ. Улсын дотор болж буй хэрэг явдал, онц чухал хэл мэдээг цаг алдалгүй Их хаанд буюу түүний залгамжлагч нарт мэдээллэх шаардлагын үүднээс өртөө албыг олноор байгуулав. Энэ алба нь маш нарийн зохион байгуулалттайгаар эмхлэгдэн тусгай элч нар бий болж зэрэг дэвийг нь тодорхойлсон тусгай таних тэмдэгээр нь онцолж харьцдаг байсан байна.

Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгөдэй хаан 1235 онд зарлиг гаргаж олон замын байнгын өртөөг зохион байгуулж байв. Энэ зарлиг дор Цагаадай болон Бат хааны улсууд тус тусын нутаг дотор салбар өртөөнүүдийг байгуулснаар Хар Хорум хоттой холбогджээ.

Өртөө зам нь Монголын эзэн гүрнийг нэгтгэн захирахаас гадна Ази, Европын хооронд соёл болон худалдаа өргөжиж, улмаар бусад улс оронтой харилцах зам нэгдэж, цаашлаад шуудан харилцаа үүсч хөгжих гол хөдөлгөгч хүч нь болсон билээ.

1691 оноос Манж улс Монголыг өөрийн харьяанд оруулснаас хойш 1911 он хүртэл 200 гаруй жилийн турш Монгол төрийн өртөө, шуудангийн албыг залгуулж байсан түүхтэй. [Монголын филатели сэтгүүл, 2014, х. 8].

1921 оны ардын хувьсгалын үр дүнд Монголын шуудангийн түүхэнд шинэ эрин үе нээгдэв. Монгол улсын шуудангийн анхны марк нь 1924 онд гарчээ. 1924 оны ҮII сарын 1-нд 1, 2, 5, 10, 20, 50 цент, 1 долларын нэрлэсэн үнэтэй таван өнгө ялгасан нэгэн багц маркийг хэвлүүлж гаргасан тухай Цахилгаан шуудангийн ерөнхий

хороо, Гадаад Явдлын яамнаас 1924 оны ҮШ сарын 2-ны өдөр Засгийн газарт өргөсөн 42/565 тоот албан бичигт дурьдсан байна.

Монголчуудын эрт дээр цагаас дийлдэшгүй бат бэхийн бэлгэдэл болгон дээдлэн шүтэж, эрхэмлэж ирсэн “Элдэв-Очир” хэмээх дүрс зургийг анхны маркан дээр залж, тухайн үед үндэсний мөнгөн тэмдэгт хараахан гараагүй байсан тул америк мөнгөний нэгжээр үнэлсэн ажээ.

Манай улсын шуудангийн анхны маркийн тухай академич Бямбын Ринчен 1958 онд “Монголчуудын шуудан, шуудангийн тэмдгийн учир” өгүүлэлдээ тодорхой тайлбарлан бичсэн байдаг. [Ринчен Б. Монголчуудын шуудан, шуудангийн тэмдгийн учир /1958 он/ Утга зохиол сонин, 1991. № 18].

Марк нь тухайн улсын түүх, соёл, ахуйн амьдрал, ан амьтан, ургамлын гэх мэт олон дүр зураг, төрхийг агуулахаас гадна шинжлэх ухааны салбаруудад харилцан уялдаа холбоог үүсгэж байдаг салшгүй нэг хэсэг нь юм.

Монголын анхны марк хэвлэгдсэнээс хойш есөн арван жил улиран одож, анхны марк “Элдэв-Очир”-оор түүчээлэн 2017 оны 9 –р сарын 8-ны байдлаар 1025 сэдвээр, 4050-4080 нэрийн марк гүйлгээнд гаржээ. Монгол шуудан компани, Монгол маркийн газраас Монгол Улсын хамгийн отгон марк “Монголын Үндэсний Олон нийтийн Телевизийн 50 жилийн ой” хэдэн өдрийн өмнө дэлхийн шуудан харилцаанд орлоо.

Монгол шуудангийн маркийг сери, нэрийн /номинал/, блок, тарифийн, уран сайхны, өглөгийн буюу нэмэгдэл үнэтэй, стикер буюу хуулж наадаг, засвартай, алдаатай, сэвтэй, нууц тэмдэглэгээтэй, логотой марк, гэрээ хэлцэлийн журмаар: тусгай зориулалтын марк, хамтарсан марк, маркийн шивээлэлтийн хувьд шивээтэй, шивээгүй, шүдгүй, давхар шивээтэй, дугуй шивээстэй, будагт шивээстэй.

Цувралын хувьд: тооны нэрээр нэгт, хоёрт, гуравт гэхчилэн одоогийн байдлаар хамгийн олон нь арван дөрөвт цуврал марк гарсан байгаа.

Материалын хувьд:

Энгийн марк ердийн цаасан, торгон, алтан, мөнгөн, холограмм /солонгорсон өнгөтэй/, алт-мөнгөн фольгон марк, бэлэг дурсгалын зориулалтаар целлюд, шаазан, эрдэнийн чулуу, үйс, мод, жимсний үнэрт, торго, даавуун марк;

Хэмжээний хувьд: блок, жижиг блок-делакс, том блок-делакс, бага хуудас /лист/, хэлхээ марк;

Бичиглэлээр нь бичвэртэй марк, хувийн дугаартай марк;

Үнийн хувьд нэрлэсэн үнэ, нүүрний үнэ, нэмэлт үнэ, тарифийн үнэ, дагавар үнэ, зах зээлийн үнэ;

Хэвлэлийн арга – литографи: чулуун бар, гүн хэвлэл, офсет хэвлэл, шат дамжлагын хувьд эх зураг, загвар (proof) марк гэх мэт арваад дамжлагатай;

Сэдвийн ангиллаар: байгаль, ан амьтан ургамал, шинжлэх ухаан, соёл урлаг, түүх нийгэм, сансар судлал, дэлхийн шашин, түүхт хүмүүс, олон улсын маркийн үзэсгэлэн, тээвэр холбоо гэх мэтээр ангилдаг, маркийн тогтсон үг хэллэг, нэр томъёо олон.

Марк нь өөрийн онцлог өнгө төрхийг хадгалахаас гадна технологи сайжрахын хирээр утга агуулга, хэлбэр дүрс, сэдвийн сонголтын хувьд өөрчлөгддөг жамтайгаас гадна маркийн сэдвийн сонголт нь тухайн маркийг бий болгох, бүтээхэд өндөр ач холбогдолтой байдаг.

Монголын филателийн холбоо, дарга С. Болдхэт, монголын марк сонирхогчдын клуб, мянгаад гишүүнтэй, идэвхтэй цуглуулагч зуу орчим, маркийн клуб ням гариг бүрийн 10 цагаас 13 цаг хүртэл “Туул” рестораны 2-р давхарт үйл ажиллагаагаа явуулдаг. Төв шуудангийн дугуй танхимд “Монгол маркийн музей” ажиллаж байна.

Франц, Англи зэрэг оронд филатели судлал (шуудангийн марк, захидлын дугтуй, ил захидлын цуглуулга) – ын академи ажиллаж, гадаадын зарим орны дунд сургуульд филателийн хичээл дугуйлангаар заадаг болсон энэ үед монголын филатели судлал тэр дундаа “хоббины хаан-шуудангийн марк” судлалыг хөгжүүлэн хүүхэд багачууд, сурагч залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, тэдний танин мэдэх, сэтгэн бодох, гоо зүйн боловсрол мэдлэгийг хөгжүүлэхэд ашиглах хэрэгтэй юм. Хүүхэд залуучууд гэлтгүй бүх

нийтээрээ цахим ертөнцөд хошуурч байгаа энэ цаг үед марк цуглуулах нь хүн хоорондын амьд харилцааг хөгжүүлэхэд ач тустай.

Улс орныхоо боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлаг уран зохиол, үүх түүхээ таниулахад монголын урлагийн үнэт өв – марк, дугтуй, ил захидлыг ашиглах хэрэгтэй гэж бодож байна.

Дэлхийн олон улсад марк цуглуулах, сонирхон судлах нь өргөжин хөгжиж байгаа энэ үед монголын шуудангийн маркийн нэр томьёо, үг хэллэгийг шууданчид, марк сонирхон цуглуулагч, маркийн клубийн хэдэн гишүүн мэдэхээс өөрөөр нийтэд дэлгэрээгүй байгаа учир толь бичиг, тайлбар толь зэрэг бүх төрлийн толь бичиг, сурах бичигт зургаар нь тайлбартайгаар оруулах, судалгааны ном товхимол гаргах, филатели судлаачдыг бэлтгэх зэргээр нийтэд өргөн хүрээтэй дэлгэрүүлэх цаг болжээ.

Монгол шуудангийн маркийн хөгжил нь Монгол улсын хөгжлийн түүхтэй салшгүй холбоотой төдийгүй Монгол улсын нэр хүнд олон улсын харилцааны түүхэнд ч онцгой байр суурь эзэлсээр байгаа юм.

Монголын маркийн 90 гаруй жилийн түүхээс үзвэл социализмын он жилүүд 1970-80 аад оны үед буддизмын сэдэвт цамын маск, өндөр гэгээн Занабазарын бүтээлүүд, сүм дуганы зурагтай марк зонхилж байсан бол улс орон зах зээлийн харилцаанд орсноос хойш монгол соёлоо сурталчилсан, тэр дундаа Улаанбаатар хотын буддын шашны гол сүм хийдүүд болох Богд хааны ордон музей, Зүүн хүрээ хийд, Чойжин ламын сүм музей, дээрх музейнүүдийн дурсгалт үзмэрүүдийг харуулсан марк, анхны өдрийн дугтуй, түүнчлэн дэлхийн шашны тэргүүнүүд, тэдний амьдрал замналыг харуулсан маркууд гарлаа.

Ном Зүй

Балганшош Л. Монгол марк каталог. Монгол шуудан ХХК. УБ хот. 2006.

Болд Ч. Монгол маркийн түүх, УБ хот. 2007 он

Ганболд Д. Монгол маркийн 90 жил. Монголын филатели сэтгүүл. 2014 он. № 2.

Гунгаажав Х. Шуудангийн марк цуглуулагч нарт тусламж. УБ. 1963 он.

Дашжав Д. Монгол марк цуглуулагчдын товч лавлах. УБ. 1993 он. Монголын филатели сэтгүүл. 2004 . № 1.

Монголын филатели сэтгүүл. 2014 . № 2, 3.

Монголын Филателийн Холбоо. Марк цуглуулагчдад гарын авлага. УБ.1995 он.

Ринчен Б. Захидал харилцааны боловсрол чухал болж байна //Хөдөлмөр сонин. 1968. 12.12. № 149.

Ринчен Б. Монголчуудын шуудан, шуудангийн тэмдгийн учир /1958 он/ Утга зохиол сонин, 1991. № 18.

Sarantuya B. Mongolian postage stamp, This is UB. УБ., 2014. # 1, p 38-41.

Чулуунгомбо Г. БНМАУ-ын Шуудангийн марк 1924-1965 он. УБ. 1959 он.

Takenori Shimizu. Монгол шуудангийн зурагт дугтуйнууд- The Mongolian illustrated postal covers. Улаанбаатар хот., 2015 он.

Чулуунгомбо. Г. БНМАУ-ын Шуудангийн марк 1924-1965 он. УБ. 1959 он.

Чулуунгомбо. Г. БНМАУ-ын Шуудангийн марк 1924-1965 он. УБ. 1959 он.

Сборник статей

**БУДДИЗМ И ТРАДИЦИОННЫЕ РЕЛИГИИ НАРОДОВ
РОССИИ, ВНУТРЕННЕЙ И ВОСТОЧНОЙ АЗИИ**

*Утверждено к печати Ученым советом
ФГБУН «Институт монголоведения, буддологии и тибетологии
Сибирского отделения РАН»*

Ответственный редактор:

Л.Е. Янгутов, доктор философских наук, профессор

Рецензенты:

Д.И. Бураев, доктор исторических наук, профессор; *Ю.А. Серебрякова*, доктор философских наук, профессор; *А.А. Базаров*, доктор философских наук, доцент

Дизайн и верстка:

ЦКР «АПГРЕЙД» (ИП Громова А.В. ИНН 032614438913)
670034, г. Улан-Удэ, ул. Хоца Намсараева, д. 7А, оф. 205
Тел. +79025-35-73-83

Издательство:

БНЦ СО РАН, г. Улан-Удэ, ул. Сахьяновой, 8

Отпечатано:

ООО «Домино» (ИН 0326038850, ОГРН 106326047935)
670000, г. Улан-Удэ, ул. Смолина, 54А
Тел. 8(3012) 21-22-22

Заказ № ДПО00000480